

## **ТӨРӨӨС 2012 ОНД БАРИМТЛАХ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ**

**УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ,**

Эдийн засаг 2011 оны эхний гурван улиралд 16.7 хувиар өсч, өмнө байгаагүй өндөр үзүүлэлттэй гарлаа. Ийм өсөлтийн суурь нь нийт эрэлтийн эрчимтэй өсөлт болж байна. Уул уурхайн томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр Монгол Улсыг чиглэсэн санхүүгийн хөрөнгийн урсгал нэмэгдлээ. Үүний дээр банкны салбарын хөрөнгийн эх үүсвэр эрс нэмэгдэж, зээл хурдтай өсч хувийн хэвшлийн өсөлтийг тэтгэж байна. Сүүлийн жилүүдэд үргэлжилж буй төсвийн тэлэлтийн нөлөө ч үүнд байгаа нь мэдээж боловч нөгөө талаар хувийн хэрэглээ, импортыг хурдтай өсгөж, нийлүүлэлтээс давсан илүүдэл эрэлт бий болгон инфляцийг өдөөж байна. Зээл хурдан өсч хэрэглээний үнэнд нөлөөлж байна. Хөрөнгийн үнэ ч нэмэгдэж байна.

Оны эхнээс тасралтгүй өсч буй эрэлтийн шалтгаантай инфляцийг хязгаарлахын тулд Монголбанк мөнгөний бодлогоо чангаруулж ирэв. Үүний дээр 5-6 сард төрийн зохицуулалттай зарим бараа, шатахууны үнэ өсч, улмаар тээврийн зардлаар дамжин бусад бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэж эхэлсэн нь мөнгөний бодлогыг чангатгах шаардлагыг улам ч нэмэгдүүлж байв.

Монголбанк төрийн мөнгөний бодлогыг эдийн засгийн өсөлтийг дунд, урт хугацаанд тогтвортой байлгахад чиглүүлж байна. Энэ нь манай өнөөдрийн нөхцөлд богино хугацааны хэт өндөр өсөлтийг дунд хугацааны уналтын урьдач шалтгаан болгохгүй байх шаардлагаар илэрхийлэгдэж байна. 2012 оны хувьд ийм бодлогын ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байлгах зорилт нь эдийн засаг тогтвортой өсөх, хөрөнгө оруулалтыг тэтгэх, төгрөгт итгэх итгэлийг хадгалах, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байх хамгийн дээд хязгаар юм. Инфляцийг 10 хувиас хэтрүүлвэл хэрэглээ, хөрөнгө оруулалт, зээл болон хадгаламжийн шийдвэр гаргалтад тодорхой бус байдлыг үүсгэнэ. Инфляцийг 10 орчим хувьд байлгалаа ч иргэдийн амьжиргааны хүрсэн түвшинг хадгалах, ядуурлыг бууруулахад хүндхэн сорилт болох нь тодорхой. Нөгөөтэйгүүр, инфляцийн ийм түвшин зээлийн хүүг бууруулахад гол саад тотгор болсоор байна. Ийнхүү инфляцийг нэг оронтой тоонд багтаах нь зөвшөөрч болох

дээд хязгаар юм. Өөрөөр хэлбэл, төсөв болон мөнгөний бодлогын хэрэглээний үнийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл нь нийт дүнгээрээ нэг оронтой тоонд багтаж байх зорилтыг дэвшүүлэх нь зүйтэй байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтөд чухал энэ зорилтыг хангахын тулд Улсын Их Хурлаас төсөв, мөнгөний бодлогын зорилтуудыг сайтар уялдуулан батлахыг хүсч байна.

Ирэх онд Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгтийн гадаад валюттай харьцах ханшийг зах зээл дэх эрэлт нийлүүлэлтээрээ тодорхойлогдон чөлөөтэй хөрвөж байх бодлогыг үргэлжлүүлэн баримтлана. Үүний зэрэгцээгээр ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлэлийг зөөлрүүлэн хүлээлтээр өдөөгдөх огцом хэлбэлзлийг арилгах арга хэмжээ авна. 2011 оны турш төгрөгийн нэрлэсэн ханш тогтвортой байгаа ч, хэрэглээний шинж чанартай импорт хурдацтай өсч байна. Урсгал тэнцлийн алдагдал эрс нэмэгдэн, ашигт малтмалын орлогоос нийт экспорт бараг бүрэн хамаарч байгаа нь эдийн засгийн гадаад шокыг эсэргүүцэх дархлааг улам ч хэврэгшүүлж байна. Гадаад зах зээл дэх эрдэс, түүхий эдийн үнэ буурах, гадаад валютын дотогшлох урсгал саарах эсвэл эргэж гадагшлах зэрэг сөрөг өөрчлөлт үүсэхэд эдийн засаг хямрах эрсдэл буурахгүй байна.

2008-09 онуудын хямралыг залган Европын холбооны зарим улс өрөө төлөх чадваргүй болж, дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал удааширч байна. Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг байгууллага дэлхийн эдийн засаг дараагийн хямрал уруу явж буйг сануулж байна. Хөгжингүй орнуудын өсөлт зогсч, уналт эхлэн хөгжиж буй орнууд, тэр дундаа Хятадын өсөлт буурч болзошгүй байна. Үүний уршгаар манай экспортын орлогыг, ялангуяа зэсийн экспортыг бууруулж, гадаад худалдааны алдагдлыг нэмэгдүүлж, төсвийн орлогыг богино хугацаанд хомсдуулж болзошгүй байна. Ийнхүү 2008-2009 оны хямралт байдал давтагдах магадлал өсч байна. Ийм учраас 2012 оны төсвийн болон мөнгөний бодлогод болзошгүй гадаад шокыг даван туулах арга хэмжээг аль болох өргөн суулгаж өгөх хэрэгтэй байна.

Улс орнууд, түүний дотор гадаад худалдааны тэнцлийн алдагдалтай улсууд өнгөрсөн хямралын дараагаас мөчлөг сөрсөн макро зохистой бодлогод шилжиж эдийн засгийн эрсдэлд өртөх шинж чанарыг багасгаж, хүндрэл бэрхшээлийг даван туулах даацыг нэмэгдүүлэх бодлого эрчимтэй хэрэгжүүлж байна. Хөрөнгийн дотогшлох урсгал өндөртэй, эдийн засаг нь хурдацтайгаар тэлж байгаа манай орон ийм макро зохистой бодлогод шилжин яаралтай хэрэгжүүлэхээс өөр гарцгүй болж

байна. Макро зохистой бодлогын гол цөм нь мөчлөг сөрсөн, харилцан уялдсан макро бодлогын хослол, цогц юм. Өөрөөр хэлбэл, нэг буруу бодлогын сөрөг нөлөөг нөгөө бодлогоор засч залруулах замаар бус, илүү тогтвортой хөгжлийн орчин бүрдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлоготой байх нь макро зохистой бодлогын гол шалгуур юм.

Байдал ийм байсаар атал сүүлийн жилүүдэд манай улс төсвийн мөчлөг дагасан бодлого хэрэгжүүлж буй нь зүйд нийцэхгүй байгааг өнөөдөр хэлэхээс өөр аргагүй байна. Төсөв хэтэрхий хурдан тэлж буйн улмаас эдийн засгийн халалт бодитойгоор нүүрлэн дотоодын нийт бүтээгдхүүний хуваарилалтад төрийн оролцоо нэмэгдэж Голланд өвчнийг тээгч гол суваг болгон хувирч байна. Төгрөг чангаран, инфляци өндөр байгаагийн улмаас төгрөгийн бодит ханш чангарч байна. Төр томрон хувийн хэвшлийн өсөлтийг шахаж байна. Үүний дээр уул уурхайн салбарт өндөр цалин нэвтэрч, төрийн албан хаагчдын цалинг огцом нэмэгдүүлж буйн улмаас манай хувийн сектор, үүн дотроо уул уурхайгаас бусад салбарын өрсөлдөх чадвар суларч байна. Эдийн засаг өсч байгаа ч иргэдийн байнгын тогтвортой орлогын өсөлт хангалтгүй байна. Өсөлтийг илүү хүртээмжтэй болгон бүтээмж, ажлын байрыг нэмэгдүүлэх, хувийн хэвшил, түүний дотор боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэхэд анхаарах цаг тулж ирээд байна.

Монголбанк мөнгөний бодлогын болон банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх арга хэмжээг өөрт буй бодлогын арга хэрэгслийг ашиглаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөнгөний бодлогын мөчлөг сөрсөн тогтвортой байдлыг цаашид нэмэгдүүлэхийн дээр эхний ээлжинд банкны салбарын эрсдэл, эдийн засгийн мөчлөгийг тогтмол тооцоолж, тухайн нөхцөл байдалд тулгуурлан макро зохистой харьцааны арга хэрэгслүүдийг оновчтой тодорхойлж ажиллахад гол анхаарлаа чиглүүлж байна. Тухайлбал, Монголбанк банкны зохистой харьцааны үзүүлэлтүүдийг мөчлөг сөрөх байдлаар тухай бүр шинэчлэн тогтоон мөрдүүлж байгаа бөгөөд энэ ажлыг цаашдын нөхцөл байдалтай уялдуулан эрчимжүүлэх болно.

Банкны салбарт хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэн, хувийн секторын хөрөнгө оруулалт, хөгжлийг тэтгэх боломж эрс дээшилж байна. Банкны салбарын өсөлтийн цар хүрээг нийт актив 2011 оны 9 дүгээр сарын байдлаар оны эхнээс 26.7 хувиар өсч 8.1 их наяд төгрөг, банкнаас олгосон зээл 48.2 хувиар өсч 4.9 их наяд төгрөгт хүрснээс харж болно. Санхүүгийн салбарын өсөн нэмэгдэж буй боломжийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад төрийн бодлогыг чиглүүлэх хэрэгтэй болж байна. Энд юуны

өмнө макро нөхцөл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал, цаад тал нь 2013 оноос төсвийн тэлэлтийг зохистой хэмжээнд барьж, инфляцийг нам түвшинд тогтворжуулан мөнгөний бодлогыг сулруулах нь нэн чухал байх болно. Ингэхгүйгээр хувийн хэвшлийн өсөлтийг дэмжиж, ажлын байр, орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж, ядуурлыг дорвитой багасах зорилтыг амжилттай хэрэгжүүлж чадахгүй билээ.

Өөр нэг чухал асуудал бол банкуудыг чадваржуулах зорилт юм. Банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, удирдлага, үйл ажиллагаагаа сайжруулахгүй бол салбарт хуримтлагдаж буй хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй дотоод саад бэрхшээлтэй тулгарах эрсдэлтэй байна. Банкны өөрийн хөрөнгө дээрх хугацаанд 27.7 хувиар өсч 820.1 тэрбум төгрөгт хүрч, өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцаа 1.5 нэгж хувиар буурч 14.3 хувь боллоо. Өөрөөр хэлбэл, банкуудын өөрийн хөрөнгийн өсөлт нь активын өсөлтөөс хоцорч байна. Иймд Монголбанкаас банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосны дээр системийн ач холбогдол бүхий том банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж өрсөлдөх болон эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, хувь нийлүүлэгчдийн хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авч байгаа бөгөөд цаашид ч улам эрчимжүүлнэ.

Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дуусч байна. “Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх ажил тулгамдаж байна.

2011 оны 9 дүгээр сарын байдлаар банкны төгрөгийн зээлийн хүү 3.3 хувь, валютын зээлийн хүү 2.0 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус буурчээ. Өнгөрсөн оноос эхлэн “Зээлийн хүү буурах эдийн засгийн зохистой орчинг бүрдүүлэх” хөтөлбөрийг Засгийн газартай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг энэ онд батлаад байна. Энэ хөтөлбөрөө чанартай биелүүлэх нь нийт эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх нэг гол чиглэл болж байна.

Монголбанк төлбөрийн системийг хөгжүүлэх, бэлэн бус төлбөр тооцоог дэмжихэд анхаарч, банк хоорондын их дүнтэй төлбөрийн систем, “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г шинээр нэвтрүүлж, холбогдох эрх зүйн баримт бичиг, журам, зааврыг шинэчлэн мөрдүүлээд байна. Ирэх 2012 онд харилцагчдад

чиглэсэн, мэдээллийн дэвшилтэт технологид суурилсан банкны үйлчилгээг нэмэгдүүлэх, системийн алдаа, зогсолт болон халдлагаас сэргийлэх нууцлалыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллана. Мөн үндэсний брэнд цахим төлбөрийн карт гаргаж, нийтийн хүртээл болгоно.

Монголбанк Мөнгөний бодлого, банкны салбарын тухай олон нийтэд сар тутам тогтсон өдөрт мэдээлж байгаа нь санхүүгийн захын тодорхойгүй байдлыг арилгах, улмаар эрсдлийг бууруулах, хүлээлтийг удирдахад нааштай үр нөлөөг үзүүлж байна. Цаашдаа ч бодлогын өөрчлөлтийн шийдвэрийг яагаад, ямар үндэслэлээр гаргасан, энэ нь инфляцийн зорьсон түвшинд хүрэх зорилттой хэрхэн уялдаж байгаа талаар нээлттэй тайлагнаж байх болно. Ингэснээр Монголбанк олон нийтэд инфляцийн төдийгүй бодит секторын төлөв байдлын талаархи мэдээллийг өгдөг болох юм.

Улсын их хурлын эрхэм гишүүдээ,

Төрөөс 2012 онд мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэж, баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.